



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/435


Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 13.4, 14.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн ахмад багш нарын “Эрдэнэтийн гүүшүүд” холбоо төрийн бус байгууллагад 2017 оны 07 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт зохион байгуулагдах туршлага солилцох уулзалтанд оролцоход 455000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 455000 /Дөрвөн зуун тавин таван мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Ахмад настны сар шинийн хүндэтгэл, нийгмийн халамжийн зөвлөлийн арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



Д.БАТЛУТ